



НИЙСЛЭЛИЙН БАГАХАНГАЙ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 01 сарын 04 өдөр

Дугаар А/02

Улаанбаатар хот

Г 2023 оны Хөрөнгө оруулалтын ажлыг Г зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1.2 дахь заалт, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны А/39 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.2023 онд нийслэлээс эрх шилжиж ирсэн ажил болон дүүргийн төсөв, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг хууль, журамд нийцүүлэн шуурхай, үр дүнтэй зохион байгуулахыг Худалдан авах ажиллагааны алба (О.Содовжамц)-нд даалгасугай.

2.Тендерт шалгарсан байгууллагатай гэрээ байгуулах, гүйцэтгэгчийн гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилтэд холбогдох байгууллагуудтай хамтран захиалагчийн хяналт тавих, гэрээт ажлыг хугацаанд нь чанартай гүйцэтгүүлэн ашиглалтад хүлээн авах, өмч хөрөнгийг бүртгэн авах, ашиглалт хамгаалалтыг тодорхой байгууллага, иргэдэд хариуцуулан ажиллахыг Засаг даргын Тамгын газар (Л.Санжийжамц)-т үүрэг болгосугай.

3.Хөрөнгө оруулалтын ажлыг гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Мягмарсүрэн)-т зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч (Б.Болормаа)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.СҮХБОЛД